

## **БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Биеийн тамир, спортын салбар 2003 онд бие даасан хуультай болж, төрийн зохицуулалт, дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн. Биеийн тамир, спортоор хичээллэгчдийн хамрах хүрээ, спортын төрөл, хэлбэрүүд нэмэгдэхийн хирээр төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд татварын бодлогоор дэмжих, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах зэрэг олон төрлийн харилцааг хуулиар зохицуулах шаардлага бий болсноор 2017 онд Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хуралаар баталсан.

Хууль батлагдсанаас хойш олон улсад биеийн тамир, спортын салбарын тулгуур бодлогын бичиг баримтууд шинэчлэгдэж, үзэл баримтлалын шинэ чиг хандлагад шилжихийг дэлхий нийтэд урайлсан үйл явдууд болсон. Тухайлбал, НҮБ-ын Бие бялдрын боловсролын харти болон Берлинний тунхаглал зэрэг бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 2017 онд Казанийн тунхгийг баталсан.

Казанийн тунхгаар баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдуулан хэрэгжүүлэхдээ Биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах, иргэдийнхээ хэрэгцээ, тухайн орон нутгийн онцлогт нийцүүлэх, оюуны болон бие бялдрын хувьд эрүүл, хөдөлмөрийн өндөр бүтээмжтэй иргэний тоог нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлдэг жишиг тогтоохыг уриалж, энэ чиглэлийн үйл ажиллагаанд төвлөрч ажиллахаар тогтсон.

2023 оны 6 дугаар сарын 26-30 өдөр Азербайжан улсын Баку хотноо зохиогдсон Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн сайд нарын олон улсын MINEPS-VII бага хурлаар "Амьдралд нийцье" ("Fit For Life") бодлогын баримтыг баталлаа. Эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт, тэгш байдал болон тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэл болох спорт, чанартай биеийн тамирын чадавхыг хэрэгжүүлэхэд "Амьдралд нийцье" хөтөлбөр нь дараах зорилт дэвшүүлэв:

- НҮБ-ын гишүүн орнуудын хүртээмжтэй спорт, чанартай бие бялдрын боловсрол, идэвхтэй хөдөлгөөний хэв маягийг хэвшүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх;
- Энэхүү салбар дахь төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

Мөн Олон улсын Олимпын хороо 2021 оны 08 дугаар сарын 08-нд Олимпын хартийг шинэчлэн баталж, биеийн тамир, спортын салбарын үзэл баримтлалыг шинэчлэн тодотгож тусгасан. Үүнд, олимпизмын тулгуур зарчмыг дараах байдлаар тодорхойлж тунхагласан:

- Олимпизм бол бие, сэтгэл, оюун санааны мөн чанарыг тэнцвэртэй хөгжүүлэх, эрхэмлэн дээдлэх амьдралын зорилго, гүн ухаан (философи) юм. Олимпизм нь соёл, боловсролыг хослуулан, боловсролын ач холбогдлыг үлгэр загвар болж, нийгмийн хариуцлага болон нийтээр тогтсон (хүлээн зөвшөөрсөн) ёс зүйн зарчмыг хүндэтгэсэн, аз жаргал, баяр баясгалан бялхсан амьдралын хэв маяг бүтээхийн төлөө байна;
- Олимпизмын зорилго бол хүний мөн чанарыг дээдлэх замаар дэлхий нийтэд энх тайвныг тогтоож, эв эе эрхэмлэсэн, хоорондоо харилцан шүтэлцсэн, нийтлэг үнэт зүйлд тулгуурлан хөгжил дэвшилийн төлөө нэгдсэн хүн төрөлхтнийг бий болгох үйлсэд биеийн тамир, спорт үйл ажиллагаа нь бусад салбараа түүчээлэхэд оршино гэж тунхагласан байна.

Өнөөдөр биеийн тамир, спортын дэлхийн чиг хандлага эрүүл чийрэг бие бялдрын хөгжлөөс гадна, хувь хүний сэтгэл, оюун санааны төлөвшил, хүмүүжил, нийгэмд эерэг харилцааг бий болгох, хувь хүн, гэр бүл, байгууллагын соёл, ёс зүй, эрхэм чанарыг тогтоох үндэс, суурь сургалтын арга, ухаан хэмээн тодорхойлох болсон.

Дэлхий нийтийн хөгжлийн дээрх чиг хандлага, цаг үеийн эрэлт хэрэгцээ, зорилтыг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар сорогоор мэдэрч, холбогдох дотоодын хууль тогтоомжийг шинэчлэх шийдвэр гаргасан.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 сарын 13 өдрийн дугаар 52 тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг батлагдсан.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн "Амьдралын чанар ба дундаж давхарга" гэсэн гурав дугаар бүлэгт "Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг ..." -ийн зорилтыг дэвшигүүлсэн бөгөөд Зорилт 3.5.-д "Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр булийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлэх"-ийн тулд 2021-2030 оны хооронд I үе шатанд "Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үе" хэмээн заасан байна.

Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд доорх агуулга бүхий зорилгыг хэм хэмжээ болгон хуульчлах шаардлагатай болсон:

- Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр булийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлэх;
- Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшилийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлэх;
- Биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо боловсронгуй болгох;
- Биеийн тамир, спортын салбарт цахим үйлчилгээ нэвтрүүлэх, үндэсний нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх;

- Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөгжил, чадавхыг нэмэгдүүлэх;
- Биеийн тамир, спортоор хичээллэх, амьдралын зөв дадал хэвшүүлэхэд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн, тохилог, таатай орчныг бий болгох;
- Биеийн тамир, спортоор хичээллэх өдөр тутмын амьдралын идэвхтэй дадал хэвшилтэй иргэн, гэр бүлийг төлөвшүүлэхэд шинэ технологи, үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг болно.

Иймд Монгол Улсын Их хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолын хавсралтын 4-т Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тусгасан.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 43 дугаар зарлигт “Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийн боловсруулж, хэрэгжилтийг хангахад авах арга хэмжээний 1.8-аар заалтаар “Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бурдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах” тухай чиглэл өгсөн.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1-д “Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бурдүүлнэ” гэж заасан нь Биеийн тамир, спортын тухай хуулийг үзэл баримтлалын түвшинд эргэн харах, шинэчлэх шаардлага үүсээд байна.

Монгол Улсад үндэсний допингийн хяналтын хөтөлбөрийг 2008 оноос эхлэн Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллага буюу ТББ хэрэгжүүлж ирсэн боловч Дэлхийн допингийн эсрэг агентлаг (WADA)-ийн Нийцлийн хяналтын хороо (CRC) нь 2023 оны 08 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан хуралдаанаараа Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагын онц ноцтой зөрчлийн асуудлыг хэлэлцэж, одоогийн нөхцөл нь Дэлхийн допингийн эсрэг дүрэмд нийцээгүй гэж дүгнэсэн.

Тус байгууллага нь Дэлхийн допингийн эсрэг дүрмээр Дэлхийн допингийн эсрэг агентлаг (WADA)-ийн өмнө хүлээсэн үүргээ зохих ёсоор хангалттай гүйцэтгэхгүй байгаагаас үүдэн Монгол Улсыг Олимп, Паралимпын наадмаас гадна бусад томоохон бүс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, арга хэмжээнд Монгол Улсын төрийн далбааг мандуулахгүй байх эрсдэл үүсгээд байгаа тухай анхааруулав.

Иймээс Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 42 дугаар тэмдэглэлд үндэсний допингийн эсрэг тэмцэх үйл ажиллагаанд

хуримтлагдсан асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах, холбогдох байгууллагуудын чиг үүрэг, ажлын уялдаа холбоо, хяналт, тэнцлийг боловсронгуй болгох чиглэлийг өгсөн нь энэ төслийг боловсруулах нэгэн бодит шалтгаан болсон.

Спортын маргааныг эвлэрүүлэн зуучлах, мэргэжлийн спортын аливаа үйл ажиллагаа оролцогч талуудын хамтын гэрээний маргаан, допингийн холбогдох маргааныг хянан шийдвэрлэх, Дэлхийн Допингийн эсрэг дүрэм, түүний хүрээнд батлагдсан олон улсын стандартуудын нийцлийг хангаж буй талаар хэрэг хянан шийдвэрлэх, спортын холбоод болон тамирчин, шүүгч, дасгалжуулагч, сонирхогч этгээдийн гаргасан спорттой холбоотой шүүхийн харьяаллын бус спортын үйл ажиллагаатай холбоотой маргааныг спортын арбитраар шийдвэрлүүлэх харилцааг зохицуулах шаардлага, хүлээлт үүсээд байна.

Ийм учраас дэлхийн болон Монгол улсын хөгжлийн чиг хандлага, цаг үеийн эрэлт хэрэгцээ, зорилтыг тусгасан дээрх эрх зүйн баримт бичгийг үндэслэсэн Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгад оруулах биеийн тамир, спортын салбарын хөгжлийн өнөөгийн хандлага, шинэ концепци, суурь зарчим, шинэ өөрчлөлт, зохицуулалт нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Биеийн тамир, спортын тухай хуулийн зохицуулалтыг бүхэлд нь шинэчлэх шаардлагатайг харуулж байгаа болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-д заасны дагуу хуулийн төслийн төрлийн хувьд шинэчилсэн найруулгын төслөөр боловсруулах бөгөөд уг төсөл нь 8 бүлэг, 40 гаруй зүйлтэй байхаар төлөвлөж, биеийн тамир, спортын салбарт тулгамдсан дээр дурдсан нөхцөл шаардлага, үндэслэлийг томьёолсон дараах зохицуулалтыг эрэмбэлэн тусгасан.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалтын хэм хэмжээг төслийн бүлэг тус бүрээр томьёолон авч үзвэл:**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**Нэгдүгээр бүлэгт** нийтлэг үндэслэл болох хуулийн зорилт, биеийн тамир, спортын хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томьёоны тодорхойлолт, иргэн, гэр бүл биеийн тамир, спортод эрхэмлэх зүйл, биеийн тамир, спортын үйл ажиллагааны зарчим, биеийн тамир, спортод эрхэмлэн баримтлах, ёс зүйн хэм хэмжээний талаар тусгасан.

Өөрөөр хэлбэл, Биеийн тамир, спортоор дамжуулан сэтгэл, оюун, бие бялдарын боловсрол олгох, идэвхтэй хөдөлгөөн, амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох зорилтыг тусгасан.

Биеийн тамир спортын салбарын ёс зүйн зарчим, хэм хэмжээг тодорхойлох, нийгэмд хүмүүнлэг боловсролын үлгэр дуурайллыг биеийн тамир, спортын салбар манлайлан оролцох, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн бол хариуцлага хүлээж байх зохицуулалтыг оруулсан.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**  
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН УДИРДЛАГА, ТОГТОЛЦОО,**  
**БҮРЭН ЭРХ**

**Хоёрдугаар бүлэгт** биеийн тамир, спортын салбарын удирдлага, тогтолцоог хуульчлах хүрээнд Улсын Их Хурлын бүрэн эрх, Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх, Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх, Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний бүрэн эрх, Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх, Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх, Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллага, Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийг тогтоосон.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ**  
**БИЕИЙН ТАМИР, СПОРТООР ДАМЖУУЛАН СЭТГЭЛ, ОЮУНЫ БОЛОН БИЕ**  
**БЯЛДРЫН БОЛОВСРОЛ ОЛГОХ, ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН**

**Гуравдугаар бүлэгт** биеийн тамир, спортоор дамжуулан сэтгэл, оюуны болон бие бялдрын боловсрол олгох, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих хүрээнд боловсролын байгууллага дахь биеийн тамирын үйл ажиллагаа, эрүүл мэндийн байгууллага дахь биеийн тамирын үйл ажиллагаа, аж ахуйн нэгж, байгууллага дахь биеийн тамир, спортын үйл ажиллагаа, зэвсэгт хүчин, хил хамгаалах, онцгой байдлын болон хууль сахиулах байгууллага дахь биеийн тамир, спортын үйл ажиллагааг зохицуулсан.

Энэ бүлэгт бие бялдрын боловсролыг дэмжих, бүх шатны боловсролын байгууллагын биеийн тамирын хичээлийн сургалтын агуулга, стандарт, хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг тогтоох, иргэдийн дунд идэвхтэй хөдөлгөөнийг эрхэмлэсэн амьдралын зөв дадлыг сурталчлан таниулах, жил тутамд нэг удаа Монгол улсын иргэдийн бие бялдрын түвшний судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилын төвийн үйл ажиллагааг улсын хэмжээнд хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгасан.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**Дөрөвдүгээр бүлэгт** спортын үйл ажиллагааны хүрээнд спортын холбоо, түүний чиг үүрэг, спортын клуб, түүний үйл ажиллагаа, биеийн тамир, спортын магадлан итгэмжлэх үйл ажиллагаа, үндэсний шигшээ баг, сургалт-дасгалжуулалтыг удирдан зохион байгуулах, спортын тэмцээн, наадмын зохион байгуулалт, мэргэжлийн спорттой холбогдох харилцааг тусгасан.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ДОПИНГИЙН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**Тавдугаар бүлэгт** допингийн эсрэг үйл ажиллагааны хүрээнд допингийн эсрэг үндэсний тогтолцоо, допингийн эсрэг үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг тусгаж, Монгол Улсын Засгийн газар, Допингийн эсрэг Үндэсний Зөвлөл, Монголын Үндэсний Олимпын Хороо болон Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага допингийн эсрэг боловсрол олгох сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг үндэсний допингийн эсрэг байгууллагатай хамтран хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтийг тусгасан.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН АЖИЛТАН, ТАМИРЧИН, ДАСГАЛЖУУЛАГЧ**

**Зургадугаар бүлэгт** биеийн тамир, спортын ажилтан, тамирчин, дасгалжуулагчийн эрх зүйн байдлыг тодотгох хүрээнд тамирчны эрх, үүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагаа, биеийн тамир, спортын ажилтны болон дасгалжуулагчийн эрх, үүрэг, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, ажил мэргэжлийн зэрэг олгох, биеийн тамир, спортын ажилтан, тамирчин, арга зүйчийн нийгмийн баталгаатай холбоотой зохицуулалтыг тусгасан.

Дасгалжуулагч, арга зүйчдийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, тэдний нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх, мөн мэдлэг, ур чадвар, ажлын бүтээмжид тулгуурласан мэргэжлийн зэрэг, шатлалтай болгож үр дүнг үнэлдэг байх, дасгалжуулагчийн шатлалын болон арга зүйчийн зэргийн нэмэгдлийн тогтолцоог боловсронгуй болгохоор эдгээр асуудлыг тусгасан.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ** **БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЭДИЙН ЗАСАГ**

**Долдугаар бүлэгт** биеийн тамир, спортын эдийн засаг хүрээнд биеийн тамир, спортын санхүүжилт, биеийн тамир, спортын үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг, биеийн тамир, спортын барилга байгууламж, сургалтын орчин, спортын хэрэглэл материалыг сайжруулах зохицуулалтыг тусгасан.

Спортын холбоо, спортын клуб, биеийн тамирын арга хэмжээ, спортын тэмцээн, наадмыг ивээн тэтгэх, спортын заал, талбай, түүний дэд бүтцийг барихад болон спортын хэрэглэл, өндөр технологи шаардсан, манай улсад үйлдвэрлэх боломжгүй тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэхэд төрөөс татварын дэмжлэг үзүүлэхээр заасан бусад хуулийн зохицуулалтыг дэлгэрүүлэн, нэмж тодотгосон.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ** **БУСАД ЗҮЙЛ**

**Наймдугаар бүлэгт** биеийн тамир, спортын салбарын гадаад харилцааг өргөтгөх, биеийн тамир, спортын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах зэрэг зохицуулалтыг тусгасан.

---ooOOoo---